

Тогоорчуу хөөрхөн, оодог муухай

Хүүхэд байхад ингэж шулганалддагсан. Чухам юу нь хөөрхөн, юу нь муухай юм бүү мэд. Бас тоодгийн мах тогоо дүүрэн гэсэн үг ч байдаг. Гэхдээ махыг нь идэж байсангүй. Бодвол өвөг дээдэс маань иддэг байсан юм болов уу. Тоодог шувууны тухай үүнээс өөр

удаа хонин тоодгийн тухай, түүний амьдрах орчны талаар сонирхуулахаар бэлдлээ.

Хонин тоодог нь Монголд төдийгүй дэлхийд ховордоод байгаа бөгөөд Азийн бүс нутагт БНХАУ-ын хойт хэсэг, ОХУ-ын Алс дорнод, Монголын нутгаар тархан суурьш-

нэлээд доошилсон гэж шувуу судлаачид хэлдэг.

Тоодгийн тоо толгой буурч байгаагийн гол шалтгаан нь түүний идээшилж буй амьдрах орчныг хүн ашиглах болсноор амьдрах орчин доройтож, зарим тохиолдолд бүр устаад байгаа аж. Жороо тоодог говийн бүс нутгаар амьдардаг бол хонин тоодог тал хээр, тариалангийн талбайн орчимд нутагшдаг. Тиймээс тариалалтын боловсруулалт хийх хугацаа нь тоодгийн өндөглөх, өндгөө дарах үетэй давхцдагаас өндөг олноор устах аюулд хүрдэг байна. Мөн тариалангийн талбайд хэрэглэдэг бордоо, химийн бодис зэрэг нь тоодогт идэш тэжээлээр нь дамжин сөргөөр нөлөөлдөг аж. Үүнээс гадна тоодгийн гол дайсан нь үнэг, хэрээ юм. Хятад болон Монголд хийгдсэн судалгаагаар олон тооны тоодог үнэгэнд баригдсан гэж дүгнэжээ. Мөн өндөр хүчдэлийн утас ч тоодогт аюултай зүйлсийн нэг. Хүнд биетэй, нисч байхдаа богино хугацаанд эргэлт хийж чадахгүйгээс олон тоодог шувуу гэрлийн утас мөргөн үхдэг байна.

Манай оронд XIX зууны сүүл, XX зууны эхээр талын бүх бүс нутагт тоодог ердийн тархацтай байсан бөгөөд цагаан зээр хаана байна тэнд хонин тоодог үзэгдэж байсан талаар Оросын эрдэмтэд дурдсан байдаг. Одоогоор Монголд хонин тоодог тархан байршиж байгаа нутгийг газар зүйн байршлаар нь авч үзвэл Улз, Онон, Хэрлэн голын сав нутаг, Халх, Нөмрөг голын сав, Мэнэн, Дарьгангын тал, Туул, Заамар, Батхаан, Хөгнөхаан, Эг, Сэлэнгэ, Тэс голын дунд хэсэг, Увс нуурын хотгор, Даланзадгад, Баянзаг гэх мэт олон газрыг нэрлэж болох юм.

Хонин тоодог нь хагас нүүдлийн

шувуу юм. Хавар, хамгийн анхны хонин тоодгийг Галуут нуурын орчмоос, мөн Улз голын дунд хэсэг Баян-Уул сумын орчимд, Нөмрөгийн дархан цаазат газарт, Хөвсгөлийн Тариалан сум, Төв аймгийн Алтанбулаг сумын Хустайн нуруунаас харж болно. 2001 оны дөрөвдүгээр сард Туул голын хөвөөнд хаврын анхны тоодгийг бүртгэсэн байдаг. Ер нь Монгол оронд гуравдугаар сарын сүүлийн 10 хоногоос дөрөвдүгээр сар шувтартал тоодог нүүдэллэн ирээд аравдугаар сарын дундуур өвөлжих нутгийн зүгт нүүдэллэдэг байна.

Хонин тоодог нь тэгш, гүвээ толгод бүхий хээр тал, голын хөндий, нуга, заримдаа төгөл ой бүхий ойт хээрт зонхилон байрших боловч хавар, намрын улиралд голдуу тариан талбайд байрладаг. Өвлийн улиралд ч тариа, өнжсөн тариан талбайг сонгох нь бий. Тоодог үржлийнхээ хугацаанд нуур, голын хөндий мэт устай орчинг бараадна. Түүний үүрлэх газрын сонголт нь ихэнхдээ тариан талбай болон түүнтэй залгаа хээр газар.

Хонин тоодгийн эрэгчин нь эмэгчнээсээ хоёр дахин том биетэй.

Өнгөний тухайд толгой хүзүү нь үнсэн саарал, нуруу нь бор шаргал судал толботой. Эрэгчин нь эрүүн дороо сахал маягийн урт цагаан өдтэй байдаг.

Тоодгийн эрэгчин 5-7, эмэгчин гурван нас хүрч үржилд ордог. Эмэгчин ихэнх тохиолдолд хоёр, хааяа гурван өндөг гаргадаг. Тоодог хосоороо амьдардаггүй бөгөөд нэг эр тоодог олон эмэгчинтэй бүл үүсгэнэ. Энэ нь зөвхөн үржлийн үед л хүчинтэй. Бусад үед тарж одооно. Эр тоодгууд үржлийнхээ үед эмэгчнээ татахын тулд хамаг өд



мэдлэг, мэдээлэл үнэндээ байсангүй. Шувуу судлаач Б.Дашнямтай уулзаж энэ тухай ярилцаж суухдаа манай оронд төдийлөн сайн судлагдаагүй шувуу гэдгийг сонсоод бага зэрэг гайхсан шүү. Учир нь дээрх холбоо үгүүдийг хүн бүр л мэддэг, тэр хэрээрээ танил санагддаг. Гэтэл энэ шувууг саяхнаас, 2006 оноос нарийвчлан судлах болжээ.

Тоодог нь Улаан номд бүртгэгдсэн ховор шувуудын нэг бөгөөд манай оронд жороо, хонин хэмээх хоёр зүйл байдаг аж. Жороо тоодог нь хонин тоодгоос биеэр арай жижиг бөгөөд жороолж явдаг учраас ийн нэршжээ. Судалгааны хувьд хонин тоодгоос бага судлагдсан байна. Тиймээс бид энэ

даг. Хонин тоодог дэлхийд 31-37 мянган тоо толгой байдаг гэсэн баримт бий. Үүнээс Зүүн Азид 4200-4500 толгой байгаа бөгөөд өндөглөж буй нутагтаа 1500-1700, өвөлждөг нутагтаа 1200-1500 толгой байдаг гэж үздэг. Харамсалтай нь энэ тоо жилээс жилд цөөрч буй. Тухайлбал, хөрш зэргэлдээ Буриадад 1985 онд 180 орчим байсан бол 1998 онд 80-90 болтлоо буурсан байдаг. Сүүлийн 50 жилд тоодгийн тоо толгой 100 дахин буурсан ба одоо Чита мужид 400-500 толгой, Тувад 40-50 толгой, зүүн хойд Хятадад ойролцоогоор 100 орчим байгаа гэнэ. Манай орны хувьд 2001 оны байдлаар 1700-1800 орчим тоодогтой гэсэн тоо байгаа ч энэ үзүүлэлт одоо

сөдөө дэрвийлгэн бүжнэ. Үүнийг шүхэрлэх гэдэг бөгөөд хэн хамгийн сайн шүхэрлэнэ, тэр олон эмэгчиний хайрыг хүртдэг аж. Тиймээс эр тоодог нэлээд удаан хугацаагаар шүхэрлэдэг бөгөөд нэг эр тоодог дунджаар 2-3 эм шувуутай үржилд ордог байна. Гурав, дөрөвдүгээр сард нүүдэллэн ирсэн шувууд дөрөвдүгээр сарын дунд үеэс сүргээрээ шүхэрлэх газраа цугларч эхэлдэг. Нам ухаа гүвээ, тэгш толгодод илүү их шүхэрлэнэ. Эм тоодог өндгөө 25-30 өдөр дарах бөгөөд үүнд эрэгчин нь оролцдоггүй.

Монгол Улсад энэ зүйл шувууг агнахыг 1980 оноос эхлэн хуулиар хориглосон байдаг. Жил ирэх тусам

ховордсоор байгаа эл шувууг хамгаалах зорилготой улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг байгуулах нь хамгааллын хамгийн чухал менежмент гэж судлаачид үздэг. Тухайлбал, тоодог өндөглөж, дэгдээхэй бойжин намар нүүдэллэсний дараа хамгааллын горим суларч, тухайн нутгийн малчид бэлчээр ашиглах боломжтой, харин хавар тоодог буцаж ирэн үржил эхлэхээс өмнө дөрөвдүгээр сарын эхээр тухайн хамгаалалттай газар нутгийг чөлөөлдөг байх хувилбарыг тэд санал болгож байгаа гэсэн.

Д.ЦОГЗОЛМАА